Төв аймгийн Баян-Өнжүүл  сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 01/64 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг дарга Орон нутагтаа бүх шатны хурлын шийдвэр Засгийн газар, аймаг, сумын стратеги зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, төр, засгийн бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлан таниулж, хүн амын эрүүл мэнд, боловсрол, соёл, хөдөлмөр эрхлэлтийн чанарыг ахиулан амьжиргааны түвшнийг дээшлүүлж, байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, төрийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, мал аж ахуй, газар тариалан, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлж, сумын эдийн засгийн чадамжийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг, аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт тодорхой биш, хэрэгжилт үр нөлөө бага байна.

Баян-Өнжүүл сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй, нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлэн Сангийн сайдын 2006 оны 388, 2015 оны 341 тоот тушаалаар баталсан загвар, аргачлалыг баримтлан тайлагнаж байна.

Аймгийн Засаг даргаас жилд 2 удаа бүх сум байгууллагад нэрэмжит үзлэг, Санхүүгийн хяналт аудитын алба 2 жил тутамд удирдамж төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт явуулдаг, байгууллага бүрд дотоод хяналтын нэгж ажилладаг боловч сумын хэмжээнд төсөв санхүүгийн сахилга бат сайжирч, алдаа зөрчил буурахгүй байна. Цаашид анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт, хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах талаар дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын эх сурвалжийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг, суурь үзүүлэлтийг санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардал 2,463,666.4 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 36,955.0 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 27,716.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлтээс тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд дахин тооцох шаардлагатай байна

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардал 2,099,632.3 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 31,494.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 5,460.5 мянган төгрөгөөр буурсан байна. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 23,620.9 мянган төгрөгөөр тогтоолоо.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг дарга нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ЗЗНДНТУТХ, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хууль болон холбогдох бусад хууль дүрэм заавры  мөрдлөг болгон ажиллаж байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсөвт байгууллага, төрийн сан, Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, эргэлтийн эмийн сан, Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан зэрэг 11 санхүүгийн тайланг нэгтгэн тайлагнасан байна.

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд Сангийн яамны Э тайлангийн нэгтгэлийн систем программыг ашиглаж байна.

***Орлогын талаар:***

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагууд тусгай зориулалтын шилжүүлгээс 960,673.3 мянган төгрөг, орон нутгийн төсвийн орлогоос 625,644.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалаас 13,812.3 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангаас 93,919.7 мянган төгрөг, нийт 1,694,049.3 мянган төгрөгийн орлого, эх үүсвэрийг төвлөрүүлэн зарцуулсан байна.

Баян-Өнжүүл сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 06 дугаар тогтоолоор сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 115,200.0 мянган төгрөг, татварын бус орлогыг 15,721.0 мянган төгрөг, нийт 130,921.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энд газрын төлбөрийг татварын бус орлогод буруу ангилан баталснаас, орлогын төлөвлөгөөнд зөрүү гарсан байна.

Орон нутгийн төсөвт 2021 онд татварын орлого 204,978.8 мянган төгрөг, татварын бус орлого 420,665.3 мянган төгрөг, нийт 625,644.0 мянган төгрөг төвлөрч, батлагдсан төлөвлөгөөг 494,723.0 мянган төгрөгөөр буюу 4.78 дахин давуулж биелүүлсэн байна.

Орон нутгийн орлогын төлөвлөгөө өндөр хувиар биелэхэд малын тоо толгойн албан татварт 46,160.9 мянган төгрөг, сумын Засаг даргатай байгуулсан Идлэг шонхор шувуу бариулах тухай 2021/02 гэрээний дагуу Арабын нэгдсэн эмират улсаас нэр заагдаж ангилагдаагүй орлогод 411,536.0 мянган төгрөг, хогны хураамжид 600.0 мянган төгрөг төвлөрүүлсэн нь нөлөөлсөн байна.

***Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:***

Үндсэн хөрөнгө дансанд 13,733.5 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 164,285.1 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор нийт

178,018.6 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн ба 76,604.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Бараа материалын дансанд худалдан авсан 174,198.9 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй хүлээн авсан 109,330.7 мянган төгрөгийн, нийт 283,529.6 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 258,343.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, хассан байна

***Авлага, өглөгийн талаар***:

Санхүүгийн нэгтгэсэн тайланд байгууллагаас авах 24,422.0 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах 266,440.7 мянган төгрөг, зээлийн хүүгийн авлага 16,687.9 мянган төгрөг, нийт 307,550.6 мянган төгрөгийн авлага нэгтгэгдсэн байна. Нийт авлагын 282,609.5 мянган төгрөг буюу 91.9 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага эзэлж байна.

Ажилчидтай холбогдсон өглөг 113.3 мянган төгрөг, байгууллагад төлөх 15,688.3 мянган төгрөг, хувь хүмүүст төлөх өглөг 45.0 мянган төгрөг, нийт 15,846.6 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

***Санхүүгийн байдлын тайлангийн талаар:***

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн харилцах дансанд 775,932.4 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн харилцах данс ба арилжааны банк дахь харилцах дансанд 4,885.9 мянган төгрөг, нийт 780,818.3 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

Бараа материал 301,271.3 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 4,542,957.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| **Мөнгөн хөрөнгө** | 154,610.6 | 780,818.3 | 626,207.7 |
| **Авлага** | 306,761.2 | 307,550.6 | 789.4 |
| **Урьдчилгаа** | 0 | 0 | |
| **Бараа материал** | 276,085.1 | 301,271.3 | 25,186.2 |
| **Үндсэн хөрөнгө** | 4,558,972.6 | 4,542,957.4 | -16,015.2 |
| **Нийт хөрөнгө** | 5,296,429.5 | 5,932,597.6 | 636,168.1 |
| **Өр төлбөр** | 755.1 | 15,846.6 | 15,091.5 |
| **Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/** | 5,295,674.4 | 5,916,751.0 | 621,076.6 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 5,296,429.5 | 5,932,597.6 | 636,168.1 |

Бараа материалын дансны үлдэгдэл 301,271.3 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс эм, боох материал 7,533.8 мянган төгрөгөөр, тусгай зориулалтын материал 2,680.4 мянган төгрөгөөр, аж ахуйн материал 14,992.8 мянган төгрөгөөр, хүнсний

материал 7,922.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нийт материалын үлдэгдэл өмнөх оноос 25,186.2 мянган төгрөгөөр өсөхөд нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,542,957.4 мянган төгрөг болж 16,015.2 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 352.8 мянган төгрөгийн байгууламж, 5,000.7 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 30,105.6 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 37,194.7 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 784.8 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 1,987.5 мянган төгрөгийн программ хангамж, элэгдэл байгуулдаггүй 1,178.0 мянган төгрөгийн ном, нийт 76,604.0 мянган төгрөгийн хөрөнгийг сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор шийдвэрлэн акталж устгасан нь голлох нөлөөллийг үзүүлсэн байна.

Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 190,805.1 мянган төгрөг, данснаас хасагдсан хөрөнгийн элэгдэл 73,375.4 мянган төгрөг байна.

Өглөгийн дансны үлдэгдэл 15,846.6 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 15,091.5 мянган төгрөгөөр өсөхөд сумын эмнэлгийн харилцагч байгууллагад төлөх бараа үйлчилгээний зардлын өглөг 8,491.8 мянган төгрөгөөр, ЕБС-ийн байгууллагад төлөх өглөг 7,196.6 мянган төгрөгөөр тайлант оны тооцоогоор үүссэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,916,751.0 мянган төгрөг болж 621,076.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сумын 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 1,954,355.6 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд болон хөрөнгийн зардалд зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Баян-Өнжүүл сумын ИТХ-ын Хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “2021 оны төсөв батлах тухай” 06 дугаар тогтоолоор 2021 онд төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 130,921.0 мянган төгрөгөөр, зарлагын нийт хэмжээг 1,884,107.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 05 дугаар тогтоолоор 2021 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 1,884,107.4 мянган төгрөгөөр тодотгон баталсан ба тусгай зориулалтын шилжүүлгийг цэцэрлэгт 20,113.3 мянган төгрөгөөр, хүн эмнэлэгт 22,371.2 мянган төгрөгөөр тус тус бууруулж, ЕБС-д 37,825.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Аймгийн ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг 2,807.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, ОНХС-ийн шилжих үлдэгдлээс санхүүжих орлогыг 108.0 мянган төгрөгөөр бууруулж зарцуулахаар төлөвлөсөн байна.

Төсвийн захирагчийн 2021 оны төсвийн төслөөс 70,248.2 мянган төгрөгөөр бууруулж санхүүжүүлэхээр баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайланд 8 хөтөлбөр арга хэмжээнд зориулан 1,749,985.7 мянган төгрөгийг урсгал зардалд, 187,532.6 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 120,000.0 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлийн зардалд, нийт 2,057,518.3 мянган төгрөг тайлагнагдсан байна. Энэ нь сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 5 дугаар хуралдааны 5 дугаар тогтоолоор баталсан төлөвлөгөө 1,884,107.4 мянган төгрөгөөс 173,410.9 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Нийт зардлын 1,102,971.4 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 689,099.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 22,371.2 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 123,076.4 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдлээс, 120,000.0 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр 1,563,409.6 мянган төгрөгийг урсгал зардалд, 59,881.3 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 40,768.0 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлийн зардалд, нийт 1,664,058.9 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 48,378.4 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,664,058.9 мянган төгрөг буюу 88.9 хувьтай хэрэгжсэн байна

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд санхүүгийн нэгтгэсэн тайланд 166,196.3 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн, бараа, ажил үйлчилгээний зардалд 107,216.8 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг буюу нэг удаагийн мөнгөн тэтгэмж, дэмжлэг, урамшуулалд 58,979.5 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 70.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Баян-Өнжүүл сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсөвт байгууллагууд, тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

- Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторууд нь тус сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 1,712.9 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт, 29,189.9 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 25,173.8

мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгч, зөвлөмж өгөгдсөн. ИТХ, Соёлын төв, ОНХС, СХС, Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн тайланг түүвэрт хамруулан шалгасан.

- Төв аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр Уваа уул аудит ХХК тус сумын ЕБС, Цэцэрлэг гэсэн 2 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан. Аудитаар ЕБС-ийн санхүүгийн тайланд 6,769.2 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 65,150.0 мянган төгрөгийн 6 зөрчилд зөвлөмж, Цэцэрлэгийн санхүүгийн тайланд 167.9 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт, 9,696.8 мянган төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж хүргүүлж, эргэлтийн эмийн сангийн тайланг түүвэрт хамруулан шалгаж, 1 зөвлөмж өгсөн байна. Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргахаас татгалзсан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Баян-Өнжүүл сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 05 дугаар тогтоолоор нийт 1,884,107.4 мянган төгрөгийн төсвийн төлөвлөгөөг тодотгон баталж, төсвийн гүйцэтгэлийн тайланд 2,057,518.3 мянган төгрөгийн төлөвлөгөөтэй тайлагнаснаар 173,410.9 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа зөрчлийг ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тодруулах шаардлагатай байна.

Нэгтгэсэн тайланд хамрагдагч байгууллагуудын татварын өр авлагын тодорхойлолтыг etax.mta.mn системээр гаргахад төсвийн нийт 5 байгууллагад 3,734.6 мянган төгрөг дутуу, 136.558.2 мянган төгрөг илүү үлдэгдэлтэй, нийт 140,292.8 мянган төгрөгийн зөрүүтэй байна. Энэ нь ТТЗ-ийн нэгтгэсэн тайлангийн өр, авлагын үлдэгдэлд тусгаагүй, орон нутгийн татварын орлогын тооцооллыг татварын байцаагч нартай тухай бүрд хийгээгүй байна.

Санхүүгийн ажилтнууд тогтвор суурьшилтай ажилладаггүй, ажилдаа туршлагажих боломж бүрдүүлээгүй солигдож, өөрчилсөн бөгөөд төсөвт байгууллагуудад дотоод хяналт бүртгэлээр тавих хяналт суларсан, цахим төлбөрийн баримтаар гүйлгээ хийгдэж байгаа эсэх, etax.mta.mn системийн татварын өр авлагын тодорхойлолттой санхүүгийн тайлан дахь өр авлага тохирсон эсэх, шилэн дансны мэдээллийг үнэн зөв, ойлгомжтой, бүрэн мэдээлсэн эсэх зэрэг асуудлаар хяналт шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 22-ны 67 дугаар тогтоолоор 5ш хаус, 2017 оны 04 дүгээр сарын 26-ны 53 дугаар тогтоолоор модон склад, эсгийний цех, 2017 оны 12 дугаар сарын 21-ний 140 дугаар тогтоолоор агропарк худалдан борлуулж, нийт 131,150.0 мянган төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдагч Баян-Өнжүүл сумын хүн эмнэлгийн санхүүгийн тайлан цаглабарт хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй учраас санхүүгийн тайлангийн аудит хийгээгүй, санал дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

ТТЗ-ийн Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 155 мэдээллээс хугацаандаа оруулсан 135 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 18 мэдээлэл, байршуулаагүй 2 мэдээлэл байна. Хэрэгжилт 94.1 хувьтай байна. Шилэн дансны мэдээлэлд нягтлан бодогчийн мэдээллийг солиогүй, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг мэдээлээгүй, дараа жилийн төсвийн төсөл болон ТЕЗ-ийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн тоон болон чанарын үзүүлэлтийг мэдээлээгүй зэрэг зөрчил гаргасан байна

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 01/178 дугаар албан бичгээр ирүүлсэн ба шилэн дансны мэдээллийг үнэн зөв гүйцэд байршуулах гэсэн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад газар эзэмших, ашиглах эрх шилжилтийн бүртгэлийн судалгааг газрын даамлаас авч татварыг бүрэн авсан эсэхийг тулган шалгах, аймгийн ИТХ-р шийдвэрлэгдсэн хөрөнгийг худалдан борлуулж, орлогыг төсөвт бүрэн оруулах асуудалд дараагийн аудитаар анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Баян-Өнжүүл сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 181,200.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 49,801.4 мянган төгрөгийн залруулга, 248.9 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 131,500.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 5 зөрчилд зөвлөмж өгөв.

Санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан Баян-Өнжүүл сумын ИТХ-ын санхүүгийн тайланд 1,185.3 мянган төгрөгийн 1 алдаанд залруулга, 1,900.0 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж, соёлын төвийн санхүүгийн тайланд 8,067.1 мянган төгрөгийн 1 алдаанд залруулга, 595.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж, сум хөгжүүлэх сангийн 187,349.7 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 832.7 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж, эргэлтийн эмийн сангийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүлж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан байна.

### 4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар орлогыг орлогын дансны хуулгатай тулгахад үйл ажиллагааны орлого 2.5 мянган төгрөг, түрээсийн орлого 94.2 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 324.8 мянган төгрөг, нэр зааж ангилагдаагүй орлого 26.7 мянган төгрөг, нийт 448.2 мянган төгрөгөөр дутуу, улсын тэмдэгтийн хураамж 203.6 мянган төгрөг, ус ашигласны төлбөр 51.3 мянган төгрөг, хүү торгуулийн орлого 115.0 мянган төгрөг, нийт 369.9 мянган төгрөгөөр илүү, нийт 818.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь:</u>* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд ЕБС, цэцэрлэг, Эмийн эргэлтийн сангийн элэгдлийн зардлыг үндсэн хөрөнгийн тодруулгад 4,426.6 мянган төгрөгөөр алдаатай нэгтгэсэн. ЗДТГ-ын 758.6 мянган төгрөгийн зардал, ЭМТ-ийн 43,798.1 мянган төгрөгийн зардлыг алдаатай нэгтгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь:</u>* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Сумын соёлын төв нь төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардал болон, санхүүжүүлэх эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн 8.067.1 мянган төгрөгөөр тохируулаагүй, зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*__Шийдвэрлэсэн нь:__* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Сумын ИТХ-ын төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн 1,185.3 мянган төгрөгөөр тохируулаагүй, зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*__Шийдвэрлэсэн нь:__* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

### 4.2 Төлбөрийн акт

Баян-Өнжүүл сумын хүн эмнэлэг нь 248.9 мянган төгрөгийг нийгмийн даатгалын байгууллагад илүү төлж авлагаар бүртгэж тайлагнаагүй, төсөвт төвлөрүүлээгүй зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-д “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “тасалбар болголт”, “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*__Шийдвэрлэсэн нь:__* Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно” заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.4-д “төсөвт

төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" бол төлбөрийн акт тогтоох гэсний дагуу шийдвэрлэв.

### 4.3 Албан шаардлага

Төв аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 22-ны 67 дугаар тогтоолоор 5ш хаус, 2017 оны 04 дүгээр сарын 26-ны 53 дугаар тогтоолоор модон склад, эсгийний цех, 2017 оны 12 дугаар сарын 21-ний 140 дугаар тогтоолоор агропарк худалдан борлуулж, нийт 131,150.0 мянган төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "толилуулга", "эрх ба үүрэг", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" үүсэн бол албан шаардлага өгөх гэсний дагуу шийдвэрлэв.

Сум хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулсан байдал болон зээлийн хугацаа хэтрэлтийг зээлдэгч бүрээр тулгахад 187,349.7 мянган төгрөгийн хугацаа хэтрэлттэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "толилуулга", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна..

*Шийдвэрлэсэн нь:* Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй" бол албан шаардлага өгөх гэсний дагуу шийдвэрлэв.

### 4.4 Зөвлөмж

Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 5 зөрчилд зөвлөмж, түүвэрт хамрагдсан байгууллагуудын санхүүгийн тайлангийн 5 зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. *Татварын мэдээ гаргалттай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлсэн боловч, төсөвт байгууллагын өөрийн орлого 55.7 мянган төгрөгөөр, бууны албан татвар 50.0 мянган төгрөгөөр, газрын төлбөр 693.2 мянган төгрөгөөр, түрээсийн орлого 102.5 мянган төгрөгөөр, нийт 4 нэр төрлийн орлого 901.8 мянган төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>:*
Орон нутгийн төсвийн орлогын дансны хуулгыг үнэн зөв боловсруулж, татварын болон татварын бус орлогыг мэдээлэх, нэр төрлийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулах

**2. *Нийцлийн аудиттай холбоотой асуудал***

*2.1. <u>Илрүүлэлт:</u>*

ТТЗ-ийн Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 155 мэдээллээс хугацаандаа оруулсан 135 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 18 мэдээлэл, байршуулаагүй 2 мэдээлэл байна. Хэрэгжилт 94.1 хувьтай байна. Шилэн дансны мэдээлэлд нягтлан бодогчийн мэдээллийг солиогүй, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг мэдээлээгүй, дараа жилийн төсвийн төсөл болон ТЕЗ-ийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн тоон болон чанарын үзүүлэлтийг мэдээлээгүй зэрэг зөрчил гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх зарчмуудыг хангуулах" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>:*
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулж зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, дотоод хяналтыг сайжруулах

**3. *Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал***

*3.1. Илрүүлэлт:*

Санхүүгийн ажилтнууд тогтвор суурьшилтай ажилладаггүй, ажилдаа туршлагажих боломж бүрдүүлээгүй сольж, өөрчилсөн бөгөөд төсөвт байгууллагуудад дотоод хяналт бүртгэлээр тавих хяналт суларсан, цахим төлбөрийн баримтаар гүйлгээ хийгдэж байгаа эсэх, etax.mta.mn системийн татварын өр авлагын тодорхойлолттой санхүүгийн тайланд дахь өр авлага тохирсон эсэх, шилэн дансны мэдээллийг үнэн зөв, ойлгомжтой, бүрэн мэдээлсэн эсэх зэрэг асуудлаар дотоод хяналт шалгалт төлөвлөж гүйцэтгээгүй зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Аудитын зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гаргаж, бүртгэлээр тавих дотоод хяналтыг тогтмолжуулж, сайжруулах

## 4. *Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал*

*4.1. Илрүүлэлт:*

Төсөвт байгууллагуудын татварын өр авлагын тодорхойлолтыг etax.mta.mn системээр гаргахад төсвийн нийт 5 байгууллагад 3,734.6 мянган төгрөг дутуу, 136,558.2 мянган төгрөг илүү үлдэгдэлтэй, нийт 140,292.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь ТТЗ-ийн нэгтгэсэн тайлангийн өр, авлагын үлдэгдэлтэй тохирохгүй зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д ”төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “тасалбар болголт”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Татварын тодорхойлолтын үлдэгдэл санхүүгийн тайлангийн өр, авлагын үлдэгдэлтэй тохирдог байх.

## 5. *Нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой асуудал*

*5.1. Илрүүлэлт:*

Нэгдсэн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн хүн эмнэлэг нь санхүүгийн тайланг цаглабрын дагуу боловсруулж Төрийн аудитын газарт ирүүлээгүй зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д “төсвийн төвлөрүүлэн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор гаргаж төсвийн ерөнхийлөн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн

тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх” заалтуудтай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “Эрх ба үүрэг”, “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Тасалбар болголт”, “Иж бүрэн байх”, “Оршин байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*
Сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах байгууллагуудын тайлан гаргалтад цаглабрыг мөрдүүлэх

### 6. Худалдан авалттай холбоотой асуудал

*6.1. Илрүүлэлт:*

Сумын ИТХ нь Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхгүйгээр ГХЗУСАЗСЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 27-ны 03 тогтоолоор 1,900.0 мянган төгрөгөөр хяналтын камер худалдан авч суурилуулсан бөгөөд хөрөнгийн дансанд бүртгээгүй байна. Э баримтаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.4-д “энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэсэнтэй нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх", " эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:
Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж байх.

### 7. Нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой асуудал

*7.1. Илрүүлэлт:*

Сумын ИТХ нь цахим баримтаар баримтжуулсан худалдан авалтын журнал ирээгүй, 2021 оны 12 дугаар сарын 16-нд Б.Энхтөрийн дансанд 1,202.2 мянган төгрөгийг шилжүүлж э баримтгүй шатахуун аваад жилийн нийт шатахууны 61.5 хувийг ажлын 11 хоногт зарцуулж дууссан боловч жолоочийн тооцоо бодсон баримтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “НХМаягт ТМ-5 ebarimt-нд үндэслэн санхүүгийн гүйлгээг хийж албан ёсны анхан шатны баримтаар бүрдүүлэх” гэсэнтэй нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Санхүүгийн гүйлгээг албан ёсны анхан шатны баримтаар бүрдүүлэх, шатахууны тооцоог бүрэн бодож байх

## 8. Нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой асуудал

*8.1. Илрүүлэлт:*

Сумын соёлын төвийн даргын 2021.12.15-ны өрийн А/13 тушаалаар караоке төхөөрөмжид 595.0 мянган төгрөгөөр үйлчилгээ хийлгэсэн бөгөөд хэвийн ажиллагаатай болсон эсэх талаар дэмжих баримтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Ажил үйлчилгээ бүрд тайлан бичиж хэвших

## 9. Тайлан, мэдээ гаргалттай холбоотой асуудал

*9.1. Илрүүлэлт:*

Сум хөгжүүлэх санхүүгийн тайлангийн авлагын үлдэгдлийг аймгийн ХХААГ-аас ирүүлсэн сангийн авлагын дүнтэй тулгахад 832.7 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Сум хөгжүүлэх сангийн авлагын дүнг ХХААГ-ийн тайлангаас зөрүүтэй мэдээлж буй зөрчлийг арилгаж, зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдлийг зөрүүгүй үнэн зөв тайлагнаж байх.

## 10. Нийцлийн аудиттай холбоотой асуудал

*10.1. Илрүүлэлт:*

Сумын ЭЭС-ийн Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс хугацаандаа оруулсан 113 мэдээлэл, хугацаа хоцроосон 29 мэдээлэл, байршуулаагүй 4 мэдээлэл байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх

зарчмуудыг хангуулах", Засгийн газрын 2016 оны 29-р тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй бөгөөд санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулж зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, дотоод хяналтыг сайжруулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | дүн | Тоо | дүн | Тоо | дүн | Тоо | дүн | Тоо | дүн |
| 1 | Баян-Өнжүүл Засаг дарга | 9 | 181,200.3 | 2 | 49,801.4 | 1 | 248.9 | 1 | 131,500.0 | 5 | 0 |

| № | Төсвийн захирагчийн ангилал | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс: | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Засаг дарга | 9 | 181,200.3 | 2 | 49,801.4 | 1 | 248.9 | 1 | 131,150.0 | 5 | - |
| 2 | ЗДТГ | 9 | 102,287.4 | 1 | 46,210.8 | 3 | 1,712.9 | 1 | 29,189.9 | 4 | 25,173.8 |
| 3 | ИТХ | 3 | 3,085.3 | 1 | 1,185.3 | | | | | 2 | 1,900.0 |
| 4 | Стөв | 2 | 8,662.1 | 1 | 8,067.1 | | | | | 1 | 595.0 |
| 5 | СХСан | 2 | 188,182.4 | | | | | 1 | 187,349.7 | 1 | 832.7 |
| 6 | БНСБСан | 0 | - | | | | | | | | |
| 7 | ОНХСан | 0 | - | | | | | | | | |
| | ТАБ дүн | 25 | 483,417.5 | 5 | 105,264.6 | 4 | 1,961.8 | 3 | 347,689.6 | 13 | 28,501.4 |
| 8 | ЕБС | 8 | 72,141.0 | 1 | 221.8 | | | 1 | 6,769.2 | 6 | 65,150.0 |
| 9 | СӨБ | 7 | 9,864.7 | | | 2 | 167.9 | | | 5 | 9,696.8 |
| 10 | ЭМТ | 0 | татгалзсан | | | | | | | | |
| 11 | ЭЭС | 1 | - | | | | | | | 1 | |
| | ХАК дүн | 16 | 82,005.7 | 1 | 221.8 | 2 | 167.9 | 1 | 6,769.2 | 12 | 74,846.8 |
| | Нийт дүн | 41 | 565,423.2 | 6 | 105,486.4 | 6 | 2,129.7 | 4 | 354,458.8 | 25 | 103,348.2 |